



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/102

Алтай хот

**“Туульсын хаан Жангар” арга  
хэмжээнд хөрөнгө гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10,11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу Юнеско-д 2009 онд бүртгэгдсэн Монгол тууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн “Монгол Жангар хайлах” өвийг хамгаалах, сурталчилах, өвлүүлэх, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй “Туульсын хаан Жангар” арга хэмжээнд нэмэлтээр гарсан 11,818,200 (арван нэгэн сая найман зуун арван найман мянга хоёр зуу) төгрөгийн зардлыг хавсралтаар баталж аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилт, ажлын чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны ...  
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ
1	Заалны тохижилтын нэмэлт зардал	3,846,000
2	Бичиг хэргийн зардал	1,365,500
3	Арга хэмжээнд оролцогчдын буудал хоолны зардал	2,694,300
4	Хөтлөгчийн хөлс	1,100,000
5	Бусад	2,812,400
Нийт дүн		11,818,200

\_\_оОо\_\_